




# ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН, 2022 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 оны 02 дугаар сарын 08

Risk Provide insight  
Do procedures support our strategy? Control  
Is management information useful & reliable? Assurance Profitability  
Guidance Internal audit  
Encourage accountability  
Catalyst for improvement Could practices compromise our reputation?  
Reputation INDEPENDENT review Implementation support  
Are we controlling what we need to control? Compliance  
Culture Cash flow forward looking  
Opportunity Follow up



Provide insight  
Do procedures support our strategy? Control  
Is management information useful & reliable? Assurance Profitability  
Guidance Internal audit  
Encourage accountability  
Catalyst for improvement Could practices compromise our reputation?  
Reputation INDEPENDENT review Implementation support Compliance  
Are we controlling what we need to control?  
Culture Cash flow Forward looking  
Opportunity Follow up



1 | 2021 оны ажлын тайлан


2 | 2022 оны ажлын төлөвлөгөө





**1 дүгээр зорилт: Хорооны тусгай зөвшөөрөл, үнэ тарифын зохицуулалтад болон эрчим хүч хэмнэлтийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулах, үйл ажиллагааг хараат бусаар үнэлж дүгнэх;**

- 1.1. Тус газрын 2021 оны дотоод аудитын ажлын голлох чиглэл нь эрчим хүч үйлдвэрлэх, түгээх хангах, дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч “ДЦС 4” ТӨХК, “УБЦТС” ТӨХК, “ЦДҮС” ТӨХК компаниудын тарифын саналыг Үнэ тариф зах зээлийн газраас хэрхэн хянасан байдалд хийх аудит хийх;
- 1.2. Хорооны хэмжээнд мөрдөгдөж буй холбогдох хуулийн хэрэгжилтийн байдалд аудит хийх;





### **2 дугаар зорилт: Хорооны зохицуулагчдаас өгсөн үүрэг даалгавар биелэлтийг хангуулж ажиллах**

- 2.1. Хорооны 2020 оны 01 тоот тушаалын биелэлтэд аудит хийх;
- 2.2. Хорооны Зохицуулагчдын зөвлөлөөс өгсөн үүргийн дагуу төлөвлөгөөт бус тусгайлан явуулах бусад аудит, судалгаа хийх;

### **Гуравдугаар зорилт: Хорооны дотоод үйл ажиллагааны хүрээнд хийгдэх аудит**

- 3.1. Үндэсний аудитын газрын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих;
- 3.2. Хорооны нэгжүүдийн эрсдэлийн үнэлгээг нэгтгэж Хороонд танилцуулах;
- 3.3. Бусад



## НЭГДҮГЭЭР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Дотоод аудитын газрын 2020 оны жилийн ажлын төлөвлөгөөг ЭХЗХ-ны 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу нэгжүүдийн эрсдэлийн үнэлгээний тайланд үндэслэн Зохицуулагчдын зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу боловсруулж Хорооны 2021 оны 04 дүгээр сарын 23–ны өдрийн 231 дугаар тогтоолоор батлуулсан.

1.1. Тус газрын 2021 оны дотоод аудитын ажлын голлох чиглэл нь эрчим хүч үйлдвэрлэх, түгээх хангах, дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч “ДЦС 4” ТӨХК, “УБЦТС” ТӨХК, “ЦДҮС” ТӨХК компаниудын тарифын саналыг Үнэ тариф зах зээлийн газраас хэрхэн хянасан байдалд хийх аудит хийх.

/Биелэлт 100 хувь/

- Үндэсний аудитын газрын 2017 оны “Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан”-д Эрчим хүчний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.1-д тариф тогтоох зарчмыг “үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах” гэж заасан боловч Зохицуулах хорооноос баталж, мөрдүүлж байгаа “Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тарифыг тогтоох аргачлал”-ын 1.28, 3.19 заалтын дагуу өмнөх 3 жилийн зардлын гүйцэтгэлд үндэслэн үнэ, тарифыг тогтоож байна. “Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ, тарифыг тогтоох аргачлал”-ын дээрх заалтуудын хүрээнд үнэ тарифыг тогтооход эрчим хүчний үнэ тарифыг хямдруулах, үйлдвэрлэлийн өртөг, зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх хөшүүрэг болж чадахгүй байгаа тул өртөг, зардлын стандарт, норм тогтоон, бодит зардалд үндэслэн үнэ тарифыг тогтоох зөвлөмж өгсөн байдаг.
- Мөн Дэлхийн банкнаас “Монгол улсын эрчим хүчний үнэ тарифын тогтолцоог сайжруулахад үзүүлэх дэмжлэг” төслийн зөвлөмжид ТЗЭ-ийн үнэ тарифын саналыг хянахдаа зардлуудын үр ашгийн үнэлгээ, шинжилгээ хийж зардлын хэмжээг үндэслэлтэй тогтоох зөвлөмжийг өгсөн.



## НЭГДҮГЭЭР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

- ДАГ-аас Эрчим хүчний тухай хууль, ЭХЗХ-ны 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифын саналыг хянах, шалгах журам”, 2014 оны 12 сарын 10-ны өдрийн 231 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлал”-ын хэрэгжилт, үр ашигт зардлын үнэлгээ буюу зардлын үндэслэлд аудитын дүгнэлт хийж өртөг зардлын үр ашгийг үнэлэх чиглэлд бодитой зөвлөмжүүд өглөө.
- ҮТЗЗГ-аас энэхүү зөвлөмжүүдийг хэрэгжүүлснээр цаашид үнэ тарифын саналыг хянахдаа үр ашигт зардалд үндэслэх, статистик, санхүү, эдийн засгийн шинжилгээний арга хэрэгслүүдийг ашиглан зардлын үр ашгийг үнэлгээ хийж бодит зардлыг тооцоолсны үндсэн дээр үнэ тарифыг тогтоосноор өртөг, зардлын өсөлтийг үндэслэлтэйгээр хязгаарлах, үр ашгийг нэмэгдүүлэх ажлын эхлэлийг тавих юм.

ТЗЭ-дийн үнэ тарифын саналыг хянасан байдалд өгсөн аудитын голлох зөвлөмжүүд дараах байдалтай байна. Үүнд:

1. ТЗЭ-ээс үнэ тарифын саналыг хүлээн авахдаа албан хэрэг хөтлөлтийн MNS 5140-2:2011 стандарт болон “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифын саналыг хянах, шалгах журам”-д заасан шаардлагыг бүрэн хангасан баримт материал хүлээн авч байх;
2. Тарифын саналыг хянахдаа тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардал болон оруулсан хөрөнгийн өгөөжийг тооцсон ашгийн зохих түвшинг хангах;



## НЭГДҮГЭЭР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

3. Улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн болон буцалтгүй тусламж, бусдаас үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгийн их засварын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, элэгдлийн зардлыг тарифт хэрхэн тусгах талаар судалж холбогдох журамд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг Хорооны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;
4. Орон тоо, түүний оновчлолын байдлыг “Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж компаниудын бүтэц, зохион байгуулалт, орон тооны хязгаарыг оновчтой тогтоох аргачлал”-ын дагуу боловсруулсан нормтой харьцуулан авч үздэг байх;
5. Үндсэн бус үйл ажиллагааны орлого, зардлыг бүртгэх журмыг боловсронгуй болгож шинэчлэн мөрдүүлэх, гадны байгууллагын тоног төхөөрөмжид хийгдэж байгаа түгээх үйлчилгээний орлого болон зардлыг тарифт хэрхэн тусгах асуудлыг судалж Хорооны хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;
6. ЭХЗХ-ны даргын 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн А125 тоот тушаалаар баталсан “ТЗЭ компаниудын дотоод хөрөнгө оруулалтын өгөөж тооцох аргачлал боловсруулах” ажлын хэсгийн боловсруулсан дагаж мөрдөх баримт бичгийг мөрдүүлэх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх;
7. Эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагааны өгөөжийн тооцооллыг ашиглалтын зардал, дотоод хэрэгцээний зардлыг хянахад авч үзэх;




## НЭГДҮГЭЭР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

8. Төлөвлөлтийг сайжруулах замаар ТЗЭ компаниудын жилийн орлого, санхүүжилтийн хэмжээг урьдчилан тааварлах боломжтой байлгах, жилийн эцэст үнэ тарифыг өөрчлөх замаар таталт хийхгүй байхыг эрмэлзэх, тодорхой хүчин зүйлүүдийн нөлөөллийг индексжүүлэх;

9. ҮТЗЗГ-ын орон тоо, бүтцийн асуудлыг эргэн харж анхны бүтцэд байсан аудиторын орон тоог сэргээж БОШХ-ний хяналтыг тухай бүрт нь хийж байх;

**1.2 Хорооны хэмжээнд мөрдөгдөж буй хуулийн хэрэгжилтийн байдалд аудит хийх; /Биелэлт 70 хувь/**

Хорооны хэрэгжүүлж буй хуулийн зүйл, заалтуудын хэрэгжилтийн явцад аудит хийж холбогдох дүгнэлтийг гарган 2021 оны 3 дугаар сард Зохицуулагчдын зөвлөлд танилцуулсан.







**2 дугаар зорилт: Хорооны зохицуулагчдаас өгсөн үүрэг даалгавар биелэлтийг хангуулж ажиллах;**

**2.1. Хорооны 2020 оны 01 тоот тушаалын биелэлтэд аудит хийх; /Биелэлт 100 хувь/**

Хорооны Дотоод аудитын дүрэм-ийн 5 дугаар зүйлийн 5.2.5, “Дотоод аудитын газрын 2020 оны жилийн ажлын төлөвлөгөө”-ний дагуу Хорооны 2020 оны зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд аудит хийж холбогдох дүгнэлт, зөвлөмжийг гаргаж Хорооны хуралд танилцуулсан. Уг зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн Хорооны даргын А/38 тоот тушаал гарч холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн.

**2.2. Хорооны Зохицуулагчдын зөвлөлөөс өгсөн үүргийн дагуу төлөвлөгөөт бус тусгайлан явуулах бусад аудит, судалгаа хийх; /Биелэлт 100 хувь/**

- Дулаанаар хангах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч “Адтай ноён” ХХК-ийн үйлчлэх хүрээг ТЗХГ-аас тогтоосон байдалд дотоод аудит хийсэн.
- Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний аудитын газраас “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт”-д хийх гүйцэтгэлийн аудитад хамрагдсан.



## ХОЁРДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

### 2.1. Хорооны 2020 оны 01 тоот тушаалын биелэлтэд аудит хийх; /Биелэлт 100 хувь/

Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны 01 тоот тушаалаар “Эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа, салбарын санхүү эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх болон хангагч хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалахад чиглэсэн зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоог бүрдүүлэх” зорилгын хүрээнд нийт 4 зорилт дэвшүүлэн, 39 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нэг. Эрчим хүчний ухаалаг сүлжээ, тогтолцоог хөгжүүлэх, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийн хяналтыг сайжруулж тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах; (14 ажил)

Хоёр. Эрчим хүчний үнэ тарифын тогтолцоог сайжруулах, зах зээлийн оновчтой загварыг нэвтрүүлэх боломжийг тодорхойлох; (9 ажил)

Гурав. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022он)-ийн хэрэгжилтийг хангах, үүрэг хүлээсэн хэрэглэгчдэд эрчим хүчний хэмнэлт гаргах, бодит үр дүнд хүрэх ажлыг зохион байгуулах; (9 ажил)

Дөрөв. Хорооны үйл ажиллагааны цахим мэдээллийн системийг өргөжүүлэн хөгжүүлэх, Эрчим хүчний салбарт зохицуулалтын байгууллага үүсч хөгжсөн түүхэн замналыг баримтжуулах; (7 ажил)



### 2.1. Хорооны 2020 оны 01 тоот тушаалын биелэлтэд аудит хийх;

Дотоод аудитын газраас Хорооны 2021 оны зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэсэн байдалд Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2 дугаар зүйлийг үндэслэж үнэлгээг хийж дараах дүгнэлт, зөвлөмжүүдийг гаргасан. Үүнд:

- Стратеги төлөвлөгөөний стратегийн чиглэл, зорилтын хүрээнд ажил төслүүдийг төлөвлөж жил бүр Хорооны 01 тоот тушаалаар баталгаажуулан ажиллаж байгаа бөгөөд стратегийн төлөвлөгөөг бодитой хэрэгжүүлэхэд эерэгээр нөлөөлж байна.
- Хорооны зорилтуудын биелэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 90 хувь буюу “Хангалттай” гүйцэтгэлтэй байсан байна. Гэсэн хэдийч цаашид зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт болон хэрэгжилтийг дүгнэхэд сайжруулах асуудлууд байна.
- Салбарыг хамарсан томоохон зорилт, ТЗЭ-чид дээр гүйцэтгэх ажил нь эзэлхүүн ихтэй, хугацаа шаардах ба зөвхөн хариуцсан газрын идэвхи чармайлтаас хамаарахгүй тул ажлын төлөвлөгөөг төсөл, дунд хугацаатай хөтөлбөр хэлбэрээр боловсруулж тухайн онд хийгдэх ажлыг төлөвлөх, төслийн менежментийн сайн туршлагыг судалж нэвтрүүлэх шаардлага байна.



## ХОЁРДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

### 2.1. Хорооны 2020 оны 01 тоот тушаалын биелэлтэд аудит хийх;

- Урт хугацааны стратегийн зорилтын шинжтэй томоохон ажлыг 1 жилд хэрэгжүүлж үр дүн гаргах байдлаар нэг өгүүлбэрээр төлөвлөсөн нь бодитой бус, хэрэгжүүлэх боломжгүй байна. Иймд ЭХЗХ-ны жил тутмын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа газар, хэлтсүүд уг ажлын хүлээгдэж байгаа үр дүн, үе шатууд, жил, сарын хуваарийг нарийвчлан гаргаж, гүйцэтгэлийг хамаарах хугацаанд нь дүгнэж байх;
- Төсөл, ажлыг төлөвлөхдөө нөхцөл байдал, шаардагдах нөөц (хүн хүч, санхүү, бусад) боломжийг уялдуулж төлөвлөх, стратеги төслүүдийн зардлыг бизнес төлөвлөгөөнд тусгаж байх;
- Хорооны жил тутмын зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, дүгнэх тухай “ЭХЗХ-ны үндсэн цалин, нэмэгдэл хөлс, шагнал, урамшууллын журам”-ын 2.5 дугаар заалтад тусгасан боловч ажлын гүйцэтгэлийг хэрхэн дүгнэх процесс, дэг жаягийг нарийвчлан тусгасан заалт байхгүй байна. Иймд Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хүрээнд гүйцэтгэлийг хэрхэн дүгнэх заалтыг нарийвчлан боловсруулж, холбогдох дүрэм журамд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй.



## ХОЁРДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

2.2. Хорооны Зохицуулагчдын зөвлөлөөс өгсөн үүргийн дагуу төлөвлөгөөт бус тусгайлан явуулах бусад аудит, судалгаа хийх; /Биелэлт 100 хувь/

- **Дулаанаар хангах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч "Адтай ноён" ХХК-ийн үйлчлэх хүрээг ТЗХГ-аас тогтоосон байдалд дотоод аудит хийсэн.**

“Адтай ноён” ХХК-иас үйлчлэх хүрээг өөрчлөх хүсэлт ирүүлсний дагуу “УБДС” ТӨХК-ийн техникийн нөхцөлд үндэслэсэн тооцоот ачаалал болон газар дээрх бодит хяналт шалгалт хийсний үндсэн дээр ЭХЗХ-ны 2021 оны 3 сарын 25-ны 200 тоот тогтоолоор үйлчлэх хүрээг 14.83 гкал/цагаар тогтоосон нь техникийн нөхцөл, анхан шатны баримт, гэрээ, бусад мэдээлэл нотолгооноос үзэхэд үндэслэлтэй байна. Цаашид зохицуулалтын чадавх, дүрэм журмыг сайжруулах, “УБДС” ТӨХК-ийн техникийн бодлогын хүрээнд үйлчлэх хүрээг тогтоох бодлого, нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх, Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйлчлэх хүрээ өөрчлөгдөх явцын хяналт, зохицуулалтын арга хэрэгслийг судалж илүү боловсронгуй болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн албан бичгээр тавьсан хүсэлтийг цаг хугацаанд нь шийдвэрлэж байх зөвлөмжийг өгсөн байна

- **Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний аудитын газраас “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт”-д хийх гүйцэтгэлийн аудитад хамрагдсан.**

2021 оны 9 дүгээр сард Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний аудитын газраас төрийн байгууллагуудын дотоод аудитын газрын чиг үүргийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлын хүрээнд дотоод аудитын дүрэм журам, төлөвлөгөө, тайлан холбогдох материалуудыг тухай бүрт нь гарган өгч, холбогдох тайлбаруудаар хангаж ажилласан байна.



3.1. Үндэсний аудитын газрын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих;

Үндэсний аудитын газраас 2021 онд Хорооны үйл ажиллагаанд зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.2. Хорооны нэгжүүдийн эрсдэлийн үнэлгээг нэгтгэж Хороонд танилцуулах; /Биелэлт 100 хувь/

Хорооны үйл ажиллагааны нэгжүүдийн 2021 оны зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг газар, хэлтэс тус бүрээр гаргуулан нэгтгэж эрсдэлийн үнэлгээг харгалзсан дотоод аудитын газрын жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулж Хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулж ажилласан.

3.3. Бусад ажил; /Биелэлт 100 хувь/

Дэлхийн банкны техникийн туслалцаатайгаар хэрэгжүүлж буй төслүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах, төслийн явцын талаар мэдээлэл солилцох, дараагийн үе шатны ажлын эзэлхүүнийг тохирч ажлын даалгаврыг боловсруулах зорилгоор ЭХЗХ болон Дэлхийн банкны удирдлагын түвшинд уулзалт зохион байгуулах, холбогдох газар, хэлтсүүдээс санал авах, материалыг орчуулах, хамтын ажиллагааны эргэх холбоог хангах чиглэлээр байнгын үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн ба зөвлөхүүд болон холбогдох газар, хэлтсүүдийг мэдээллээр ханган “Төслийн нэгж”-ийн үүргийг гүйцэтгэж ажилласан байна.

- Газрын дарга, ажилтнууд тайлант хугацаанд 6 ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнд ажилласан байна.



# ГУРАВДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

3.2. Хорооны нэгжүүдийн эрсдэлийн үнэлгээг нэгтгэж Зохицуулагчдын зөвлөлд танилцуулах;  
Хорооны 2022 оны зорилтуудыг биелүүлэхэд нэгжүүдийн учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээний матриц дараах байдалтай байна.

ЭРСДЭЛИЙН ТОО, ТҮВШИН

2021 он

ТОХИОЛДОХ МАГАДЛАЛ	6					
	5				D1	
	4		B5	A1,B14,B16,B17,C3	A2,B2,B6,B7	
	3		B10,B11,C1,C2	B12,B13,B15,B18,C4	B3,B4	
	2			B8,B9		B1
	1					
		1	2	3	4	5

ЭРСДЭЛИЙН ТОО, ТҮВШИН

2022 он

ТОХИОЛДОХ МАГАДЛАЛ	6					
	5				YTB10	
	4			33B1,B6; T3D2	YTB2,B6,B10; ЭХХВ3, T3B2,B5; 33B2	
	3			T3-A23УВ3-6,B4-3, ХОВ8- 10,18; ЭХХС1,13; T3C1; ЗУС4	YTB7,T3B6,T3D1,	
	2					YTB4
	1					
		1	2	3	4	5

Аудит хийгдэх эрсдлүүд	Эрсдэлийн нийт тоо түвшин	Ач холбогдлын зэрэг	Аудит хийгдэх эсэх
D1	20	5	Хамгийн их баталгаа өгөхөөр аудит
B1	10	5	Хамгийн их баталгаа өгөхөөр аудит
A2,B2,B6,B7	16	4	Хамгийн их баталгаа өгөхөөр аудит
B3,B4	12	4	Хамгийн их баталгаа өгөхөөр аудит
A1,B14,B16,B17,C3	12	3	Ердийн баталгаа өгөхөөр аудит
B12,B13,B15,B18,C4	9	3	Ердийн баталгаа өгөхөөр аудит
B8,B9	6	3	Ердийн баталгаа өгөхөөр аудит
B5	8	2	Ердийн баталгаа өгөхөөр аудит
B10,B11,C1,C2	6	2	Нөөц боломжтой үед аудит хийх

Аудит хийгдэх эрсдлүүд	Эрсдэлийн нийт тоо түвшин	Ач холбогдлын зэрэг	Аудит хийгдэх эсэх
YTB10	20	5	Хамгийн их баталгаа өгөхөөр аудит
YTB2,B6,B10; ЭХХВ3, T3B2,B5; 33B2	16	4	Хамгийн их баталгаа өгөхөөр аудит
YTB7,T3B6,T3D1, 33B1,B6; T3D2	12	4	Хамгийн их баталгаа өгөхөөр аудит
YTB4	10	5	Хамгийн их баталгаа өгөхөөр аудит
T3-A23УВ3-6,B4-3, ХОВ8- 10,18; ЭХХС1,13; T3C1; ЗУС4	9	3	Ердийн баталгаа өгөхөөр аудит

**Ач холбогдлын зэрэг:**

- 1 бол хүлээн зөвшөөрч болохуйц
- 2 бол тухайн эрсдэл гарах магадлалыг нь багасгах
- 3 бол тухайн эрсдэлийн учруулах хор нөлөөг бууруулах
- 4 бол эрсдэлийн нөлөөг бусдад шилжүүлэх
- 5 бол тухайн эрсдэлийг дахин гаргахгүй байх гэсэн чиглэл баримжаалж эрсдэлийг удирдах арга хэмжээг тодорхойлно.

Эрсдэлийн тоо 2021 оноос өссөн (25→26)

Эрсдэлийн түвшин өмнөх оны түвшид







# ГУРАВДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

## • ЭХЗХ-ны эрсдэлийн үнэлгээ

А. Төсөв, санхүүгийн эрсдэл		Газар, хэлтэс	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах эзэн	
1	Цалин урамшууллын систем ажлын ачаалал, хариуцлагатай уялдахгүй байх.	9	ТЗХГ А2	Цалин хөлс урамшууллын системийг ажлын үр дүнтэй холбох	ЗУГ, Хүний нөөцийн мэргэжилтэн
<b>В. Үйл ажиллагааны эрсдэл</b>					
1	ТЗЭ-чид тарифын санал, тооцооллыг аргачлалын дагуу хийхгүй, нотлох баримтыг бүрдүүлэхгүй, мэдээллийг үнэн зөв ирүүлэхгүй байх.	16-12↓	ҮТЗЗГ В2	Тарифын санал ирүүлэх, бүрдүүлэх материал, мэдээллийн үнэн зөв байдлыг хянах үйл ажиллагааг сайжруулах	ҮТЗЗГ
2	Ур чадвартай боловсон хүчин дутагдалтай байдлаас шалтгаалан үйл ажиллагаа доголдох.	16-12↓	ЭХХГ В3	Нэгжийн сар бүрийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь хэмжээний биелэлтийн дүнгээс нэгж10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд 10 хүний 6 хүн сарын төлөвлөгөөт ажлыг бүрэн гүйцэтгэж ажилласан байна. Цаашид Ажилтнуудын мэдлэг ур чадварыг стандартын шаардлага хангуулах, ур чадвар, чадавх, туршлагыг нэмэгдүүлэх шаардлагатай.	ЗУГ
3	Мэдээллийн технологийн аюулгүй байдал алдагдах (компьютер дээрх мэдээлэл устах, вирустэх).	10	ҮТЗЗГ В4	Сүлжээний аюулгүй байдлыг сайжруулах, халдлагаас урьдчилан сэргийлэх	ЗУГ, МТ мэргэжилтэн
4	Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцлийг хууль эрхзүйн чадамжтай эсэхийг үнэлэх, тодорхойлох боломжгүй	16	ТЗХГ В2	ЭХБББ ТЗЭ-ийн ХО гэрээ хэлцлийг хууль эрхзүйн чадамжтай эсэхийг үнэлэх шалгуурыг тодорхой болгох	ТЗХГ
5	ТЗЭ компаниудын ирүүлсэн (үнэ тарифын болон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын зорилтын) мэдээллийн үнэн зөв байдлыг газар дээр нь шалгах боломж хангагдахгүй байх.	16	ҮТЗЗГ В6	ТЗ болон тарифын аудит, мониторингийг газар дээр нь хийх боломжийг бий болгох	ҮТЗЗГ, ТЗХГ
6	Үнэ тарифын мэргэжилтнүүдийн орон тоо, мэдлэг боловсрол, ур чадвар, ажлын дадлага туршлага дутмаг байх.	12-16↑	ҮТЗЗГ В7	Нэгжийн хэрэглэгчийн үнэ тариф хариуцсан мэргэжилтэн, бүс нутгийн үнэ тариф хариуцсан мэргэжилтэн дутуу байсан одоо ажиллаж байгаа бүрэлдэхүүн нөхөж ажилладаг тус ажлын байранд тавигдах шаардлагыг хангах чадамжтай хүний нөөц дутмаг, нэг хүнд ногдох ажлын ачаалал их . Цаашид тус нэгжийн ажиллах хүчний тоог ажлын ачаалалд нийцсэн байдалд хүргэж нэмэгдүүлэх.	ЗУГ



# ГУРАВДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

## • ЭХЗХ-ны эрсдэлийн үнэлгээ

### В. Үйл ажиллагааны эрсдэл

7	ЭХБББ тусгай зөвшөөрлийн зарим шаардлагуудын дүгнэх үзүүлэлтүүд хүндрэлтэй	16	ТЗХГ В5	ЭХБББТЗЭ-ийн шаардлагыг, төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй харьцуулан тогтоох, шалгуур үзүүлэлтийг дүгнэх үзүүлэлттэй уялдуулан тодорхой болгох	ТЗХГ
8	Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, зорилтын хэрэгжилтэд хяналт шалгалт хийхэд туршлагатай мэргэшсэн боловсон хүчин дутагдах	12-9↓	ТЗХГ В6	Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хэрэгжилтэд иж бүрэн хяналт шалгалт хийхэд туршлагатай, мэргэшсэн мэргэжилтэн дутмаг. Цаашид мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх, бүрдүүлэх шаардлагатай.	ЗУГ
9	ТЗЭ компани, байгууллагуудын нууцтай холбоотой мэдээлэл задрах	9	ЗУГ В3-6	ТЗЭ компаниудаас ирүүлж байгаа мэдээллийн нууцлалын ангилж, түвшинг тодорхойлж нууцлалтай мэдээллийг хамгаалж ажиллахыг албан тушаалын тодорхойлолтын ажил үүрэгт тусгах,	АА, ЗУГ
10	Хорооны үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамж дунд;	9	ЗУГ В4-3	Олон нийтэд Хорооны үйл ажиллагааг суртачлах	АА, ЗУГ
11	МУЗГ-аас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөрийг төрөөс хариуцахтай холбоотой ТЗЭ компаниуд мэдээллийг үнэн зөв ирүүлэхгүй байх.	16	ҮТЗЗГ В10	Мониторинг, эргэх холбоотой хяналт шалгалтыг сайжруулах	ҮТЗЗГ
12	Нэг мэргэжилтэнд ногдох өргөдөл гомдлын тоо их, ачаалал өндөр байгаагаас маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлэж амжихгүй байх,	9-12↑	ХОНХ В8	Хэрэглэгчдийн өргөдөл гомдлыг судлах, барагдуулах механизм процессыг сайжруулах гарц гаргалгаа бий болгох. жишээ нь (Хороо болонТЗЭ-чидийн хэрэглэгчдийн өргөдөл, гомдол шийдвэрлэх цогц цахим системтэй болох тус цахим системийн өргөдөл шийдвэрлэх үе шатыг өргөдөл гомдол шийдвэрлэх эрх зүйн баримт бичгийн хүрээнд цахим системийн ажиллагааг зохицуулах, өргөдөл шийдвэрлэхэд шаардлагатай бүрдлийг цэсд оруулсан байх , өргөдөл шийдвэрлэлтийг хангагч байгууллага шийдвэрлэсэн байдалд Хороо үнэлэлт өгч ажилласнаар өргөдөл гомдол буурах боломж бүрдэнэ). үр дүн :Өргөдөл гомдлын шийдвэрлэх үйл ажиллагаа болон хугацаа буурах боломж бүрдэж болох юм.	ҮТЗЗГ, ТЗХГ



## ГУРАВДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

### • ЭХЗХ-ны эрсдэлийн үнэлгээ

№	Эрсдэлийн нэр	Эрсдэлийн үнэлгээ	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	
<b>В. Үйл ажиллагааны эрсдэл</b>				
13	Хорооны газар, хэлтсүүдийн хоорондын мэдээлэл солилцоо бага байгаагаас гадагшаа чиглэсэн мэдээлэл, харилцаанд эрсдэл үүсдэг	9	ХОНХ В9 Газар хэлтсүүдийн ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагаа/мэдээллийн урсгалыг сайжруулах	ЗУГ
14	Хорооноос гарсан тогтоол, шийдвэрийн хяналт дутмаг байгаагаас ТЗЭ, хэрэглэгчид мэдэхгүй, мөрдөхгүй байх	9	ХОНХ В10 Хорооноос гарсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах	ЗУГ
15	АНЗЗ-ийн орон тооны гишүүд ТЗЭ-дийн техникийн болон санхүүгийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, ТЗЭ дээр гарсан зөрчил, дутагдалтай асуудлыг залруулахад шаардлагатай арга хэмжээг авахгүй явсаар даамжруулах	9	ХОНХ В18 АНЗЗ-ийн үйл ажиллагааны хяналтын үйл ажиллагааг сайжруулах	ХОНХ
16	Ажлын байрны тодорхойлолтод ажилтны үүрэг, хариуцлага, ажлын үр дүн тодорхой бус тусгагдсанаас ажлын давхардал, хийдэл гарах;	12-9↓	33СХАХВ1 Ажлын байрны тодорхойлолтыг газар хэлтсийн зорилго зорилттой холбох, Ажилтны үүрэг, хариуцлага, ажлын үр дүнг илүү тодорхой тусгаж ажлын давхардал, хийдлийг арилгах;	ЗУГ
17	Оролцогч талууд, газар, хэлтсүүдийн ажлын уялдаа холбоо дутагдсанаас үр дүн буурах,	16	33СХАХВ2 Газар хэлтсүүдийн ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагаа/мэдээллийн урсгалыг сайжруулах	ЗУГ
18	Гүйцэтгэлийн мониторинг, эргэх холбоо доголдоноос гүйцэтгэлийн сул талыг илрүүлж залруулах, байнгын сайжруулалт хийгдэхгүй байх,	12	33СХАХВ6 Гүйцэтгэлийн үнэлгээний системийг сайжруулах	ЗУГ



# ГУРАВДУГААР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

## • ЭХЗХ-ны эрсдэлийн үнэлгээ

№	Эрсдэлийн нэр	Эрсдэлийн үнэлгээ	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	
<b>В. Үйл ажиллагааны эрсдэл</b>				
<b>С. Нийцлийн буюу эрх зүй зохицуулалтын эрсдэл</b>				
1	Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжууд хоорондоо зөрчилтэй	9	ЭХХГ С1 Хоорондоо зөрчилтэй хуулийн зүйл заалтуудын талаар санал бэлтгэж холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, Хуулийн сургалт, кейсийн хэлэлцүүлгүүдийг тогтмол явуулж байх	ЗУГ, Хуулийн зөвлөх
2	Тусгай зөвшөөрөл олгох хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаанд хууль журамд заасан хугацааг мөрдөхгүй байх.	9	ТЗХГ С1 Тусгай зөвшөөрөл олгох хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаанд хууль журамд заасан хугацааг мөрдөж ажиллах;	ТЗХГ
3	Хорооны гаргасан шийдвэрийг үл зөвшөөрч шүүхийн байгууллагад хандах	9	ЗУГ С4 Нэгжийн мэргэжилтнүүд Хорооны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн эрх зүйн баримт бичгийн бүртгэлийн судалгааг гаргаж, эрх зүйн актын гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөллийн шинжилгээг хийж ажиллах. Эрх зүйн актын хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацаанаас хамааруулан шинжилгээг хийх хугацааг тодорхойлох.	АА, ЗУГ
4	Үүрэг хүлээсэн хэрэглэгчид хууль тогтоомжийг ойлгож хэрэгжүүлэхэд хойрго хандах	9	ЭХХГ В13 Хуулиар хүлээсэн үүргийн талаарх мэдлэг, ойлголт Тогтоол шийдвэрийг танилцуулах, хяналт мониторинг, тайлагнах систем үйл ажиллагааг сайжруулах,	Холбогдох газар хэлтсүүд үйл ажиллагааны
<b>Д. Гадаад хүчин зүйлсийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн</b>				
1	СЭХ-ний эх үүсгүүрүүдээс НС-нд нийлүүлэх ЦЭХ-ний хэмжээг тарифт тооцсон дүнгээр үйлдвэрлэл, хэрэглээний төлөвлөгөөнд тусгаж байгаа боловч ТЗЭ компаниуд ЦЭХХАГ-нд тусгагдсаны дагуу нэгдсэн сүлжээнд нийлүүлэх цахилгаан эрчим хүчний хэмжээг нэмэгдүүлэх талаар гомдол маргаан үүсгэх.	20	ҮТЗЗГ В10 Холбогдох хууль тогтоомж, гэрээний хүрээнд асуудлыг судалж шийдвэрлэх,	ҮТЗЗГ, Хуулийн зөвлөх
2	Шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд нөлөөлөх үзүүлэх	12	ҮТЗЗГ D1 Гадаад хүчин зүйлийн нөлөө болох эрчим хүч хэрэглэгчийн үнэ тариф өөрчлөх шийдвэрт иргэд болон аж ахуй нэгжийн санхүүгийн чадамжтай уялдуулан засгийн газраас хорооны зохицуулалтын шийдвэрт шууд бус нөлөө үзүүлэх эрсдэл байна. Иргэдийн төлбөр төлөх чадамжаас хамааралтай эрсдэл. Зохицуулалтын үйл ажиллагааны хараат бус байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай.	Холбогдох газар хэлтсүүд
3	ТЗЭ-чид хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, Тусгай зөвшөөрөл олгогчийн шийдвэрийг дагаж мөрдөхгүй байх, ёс зүй хандлага зохисгүй байх	12	ТЗХГ D2 Хуулиар хүлээсэн үүргийн талаарх мэдлэг, ойлголт тогтоол шийдвэрийг танилцуулах, хяналт мониторинг, тайлагнах системийг сайжруулах,	ТЗХГ



## БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:

ДАГ-аас 2021 онд дараах 6 ажлын хэсэгт ажилласан байна. Үүнд:

❖ Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн цахилгаан, дулааны эрчим хүчийг төрөөс хариуцах төлбөрийн гүйцэтгэлийг хянах;

*“УБЦТС” ТӨХК, “БЗӨБЭХС” ТӨХК, “ЭБЦТС” ТӨХК, “ББЭХС”, “АУЭХС”, “ДДС” ТӨХК, “Нолго” ХХК, “Баатар дулаан хан” ХХК-уудад 2021 оны 2-6 дугаар сарыг дуустал хугацаанд хяналт, шалгалтын ажлыг гүйцэтгэж дүгнэлт, зөвлөмж гарган үр дүнг Эрчим хүчний сайдад танилцуулсан.*

❖ “Нэг худалдан авагчийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээ хийх аргачлал”-ыг боловсруулах;

❖ Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд Эрчим хүчний салбарт 100 мянган мод тарих зорилгоор Хорооны даргын 2021 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн А/68 тоот тушаалаар ажлын хэсэгт ажиллах;

❖ Цахилгаан түгээх, хангах ТЗЭ компаниудын мөнгөн урсгал, зардлын харилцах дансны үлдэгдлийг шалгаж дүгнэлт гаргах;

*ЭХЗХ-ны 2021 оны 9 сарын 13-ны 1/818 тоот албан бичгээр тайлан, дүгнэлтийг хүргүүлсэн.*

❖ ЭХЗХ-нд Тэнцвэржүүлсэн үнэлгээний системийг нэвтрүүлэх;

*Дэлхийн банканд хүсэлт гарган “Тэнцвэржүүлсэн үнэлгээний системийн мэргэшсэн зөвлөх бэлтгэх “Balanced Scorecard Professional” гэрчилгээт 4 өдрийн сургалтыг Энэтхэг улсын “Middle Earth HR” компанитай хамтран зохион байгуулж хорооны зохицуулагч, газар хэлтсийн дарга 20 ажилтныг оролцуулж “Тэнцвэржүүлсэн үнэлгээний системийн мэргэшсэн зөвлөх”-ийн гэрчилгээ олгосон. Гэрчилгээт сургалтын дараагийн шатанд Хорооны стратеги төлөвлөгөөг боловсруулах чиглэлээр зөвлөх үйлчилгээ авч Хорооны алсын хараа, эрхэм зорилгын хувилбарыг боловсруулсан.*

❖ Хорооны 20 жилийн ойд зориулсан стратеги төлөвлөлтийн талаарх баримтат кино бүтээх;

*/Ажлын хэсэгт ажиллаж газар, хэлтсүүдээс ЭХЗХ-ны 2018-2021 оны стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийг гаргуулан нэгтгэж үндсэн зохиолыг гаргасан. /*



## ЖИЛИЙН АЖЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

- 2021 онд нийт 9 ажил хийхээр төлөвлөснөөс 8 ажил бүрэн хийгдсэн, 1 ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна. /Дундаж 96 хувь/
- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу холбогдох ажлын хэсэгт ажиллаж өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрд нь биелүүлж тайлагнаж ажилласан байна.





## ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажлууд	Хэрэгжүүлэх хугацаа	Хүрэх үр дүн
1.	Хорооны 2021 оны 01 тоот тушаалын биелэлтэд аудит хийх;	1 дүгээр улиралд	2021 оны 01 тоот тушаалын биелэлтийг дүгнэн холбогдох зөвлөмж гаргасан байна.
2.	Тусгай зөвшөөрлийн зохицуулалтад аудит хийх; (Цахилгаан түгээх хангах 1, Дулаан түгээх, хангах 1 компани дээр хийх)	2 дугаар улиралд	Аудит хийгдэж зөвлөмж гарсан байна.
3.	Хэрэглэгчийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд түүвэрчилсэн байдлаар аудит хийх;	3 дугаар улиралд	Аудит хийгдэж зөвлөмж гарсан байна.
4.	Дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифыг хянасан байдалд аудит хийх; (Дулаан түгээх, хангах -2 компани дээр хийх)	4 дүгээр улиралд	Аудит хийгдэж зөвлөмж гарсан байна.
5.	Эрчим хүч хэмнэлтийн газрын чиг үүргийн биелэлтийн байдалд аудит хийх;	Жилдээ	Аудит хийгдэж зөвлөмж гарсан байна.
6.	Холбогдох байгууллагаас Хороонд өгсөн үүрэг, даалгаврын биелэлтэд болон Үндэсний аудитын газар (ҮАГ)-ын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих;	Жилдээ	Зөвлөмжийн биелэлтийг хангах чиглэлд ажлууд хийгдсэн байна.
7.	Хорооны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх;	Жилдээ	Аудит хийгдэж зөвлөмж гарсан байна.
8.	Хорооны Зохицуулагчдын зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу Хорооны тогтоолын биелэлт болон тусгайлан явуулах бусад аудит, судалгаа хийх;	Жилдээ	Тухайн чиглэлээр аудит хийгдэж холбогдох дүгнэлт, зөвлөмж гарсан байна.

# ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ :

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны ... дүгээр  
Улаанбаатар хот  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Дотоод аудитын газрын ажлыг дүгнэх,  
төлөвлөгөө батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.23, 9.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос **ТОГТООХ нь:**

1. Дотоод аудитын газрын 2021 оны ажлыг “Хангалттай” үнэлгээтэйгээр дүгнэсүгэй.
2. Дотоод аудитын газрын 2022 оны ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
3. 2022 оны ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Дотоод аудитын газар /Ч.Цоодол/-т үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны дарга /А.Тлейхан/-д даалгасугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН


ЗОХИЦУУЛАГЧ

Б. БАТТУЛГА

ЗОХИЦУУЛАГЧ

Э.САМДАН





**Газрын зорилго:** Дотоод аудитын газрын үйл ажиллагаа нь Эрсдэлийн удирдлага, Хяналтын аливаа үйл ажиллагааны үр дүнг хараат бусаар үнэлж дүгнэн, зөвлөмж гаргах замаар Хорооны үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

**Дотоод аудитын газрын үндсэн чиг үүрэг:** холбогдох хууль тогтоомжийн дагуу ЭХЗХ-ны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт болон дотоод аудитыг хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөх, удирдлагыг шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй ажиллана.



# ДАГ-ЫН 2018 ОНД ХИЙСЭН АЖИЛ

Үндэсний аудитын газраас 2016, 2017 онуудад Хороонд аудит хийж байгууллагын дотоод хяналтын нэгжийг байгуулж ажиллуулах зөвлөмжийг өгсөн.

2018 оны 06 дугаар сарын 259 дүгээр тогтоолоор ДАГ-ыг байгуулж, 301 дүгээр тогтоолоор “Дотоод аудитын дүрэм”-ийг баталсан.

## Бүтэц, зохион байгуулалтын зураглал



ДАГ-аас 2018 онд дараах үйл ажиллагаанд аудит хийж, зөвлөмж өгсөн:

1. Хорооны 2016 оны 11 дүгээр сарын 01-ээс 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд гарсан тогтоол нь хурлын материал, хэлэлцүүлэгтэй нийцсэн байдалд;
2. Эрчим хүчний барилга байгууламж барих (СЭХ) тусгай зөвшөөрөл олгосон үйл ажиллагаанд;
3. Эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүсч буй шинээр ашиглалтад орох сэргээгдэх эрчим хүчний Тусгай зөвшөөрөл эзэмшигч 4 компанийн үнэ тарифын зохицуулалтад;

- Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын календарьчилсан төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж сар бүр үзүүлэлт тус бүрээр дүгнэн Хорооны зохицуулагчдад танилцуулсан.
- Хорооны нэгжүүдийн эрсдэлийн үнэлгээг тухайн нэгж тус бүртэй хамтран гаргаж, Хорооны нэгдсэн эрсдэлийн матрицыг гаргасан. Эрсдэлийн матрицыг харгалзан ДАГ-ын аудит хийх төлөвлөгөөг боловсруулж байна.



# ДАГ-ЫН 2019 ОНД ХИЙСЭН АЖИЛ

Хорооны 2019 оны зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд дотоод аудит хийж аудитын тайлан зөвлөмжийг Хорооны Ажлын албанд хүлээлгэн өгсөн.

## Бүтэц, зохион байгуулалтын зураглал



ДАГ-аас 2019 онд дараах үйл ажиллагаанд аудит хийж, зөвлөмж өгсөн:

1. Сэргээгдэх эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч 4 компанийн тусгай зөвшөөрөл, үнэ тарифын зохицуулалтад;
2. 2018 оны Хорооны хуралд Зохицуулагчдаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн хэрэгжилтийн байдал;
3. Хорооны нийт ажиллагсдын ажлын байрны тодорхойлолт, нэгжүүдэд ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн хариуцан хийж буй ажлын зорилго, цар хүрээ нь хангалттай байгаа эсэхийг тодорхойлох;
4. Хорооны санхүүгийн үйл ажиллагаанд;

## Бүтэц, зохион байгуулалтын зураглал



ДАГ-аас 2020 онд дараах үйл ажиллагаанд аудит хийж, зөвлөмж өгсөн:

1. Үнэ тариф, зах зээлийн газрын Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтсийн чиг үүргийн биелэлтийн байдалд;
  2. Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа зарим үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн нөхцөл байдалд;
  3. “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн Нэг худалдан авагчтай загварын хэрэгжилтийн байдал, Төвийн бүсийн эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний төлөвлөлтийн байдалд;
- Хорооны даргын 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/10, А/12, А/13, А/70 тоот зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай тушаалын биелэлтэд;
  - Хөндлөнгийн аудитын зөвлөмжийн дагуу хийгдэж буй ажлын явцад хяналт тавин ажиллаж байна.

## Бүтэц, зохион байгуулалтын зураглал



ДАГ-аас 2021 онд дараах үйл ажиллагаанд аудит хийж, зөвлөмж өгсөн:

1. Эрчим хүч үйлдвэрлэх, түгээх хангах, дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч “ДЦС 4” ТӨХК, “УБЦТС” ТӨХК, “ЦДҮС” ТӨХК компаниудын тарифын саналыг Үнэ тариф зах зээлийн газраас хэрхэн хянасан байдалд ;
2. Дулаанаар хангах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч “Адтай ноён” ХХК-ийн үйлчлэх хүрээг ТЗХГ-аас тогтоосон байдалд;
3. Хорооны хэмжээнд мөрдөгдөж буй хуулийн хэрэгжилтийн байдалд;



# ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД АУДИТЫН ГАЗРААС АУДИТ ХИЙСЭН ЗУРАГЛАЛ





# ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН АУДИТ ХИЙГЭЭГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## ТЗХГ

1. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл (уламжлалт эх үүсвэр)-ийн зохицуулалт;
2. Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрлийн зохицуулалт;
3. Цахилгаан дамжуулах тусгай зөвшөөрлийн зохицуулалт;
4. Цахилгаан импортлох тусгай зөвшөөрлийн зохицуулалт;
5. Эрчим хүч үйлдвэрлэх (ДЦС) тусгай зөвшөөрлийн зохицуулалт;
6. Цахилгаан түгээх, хангах тусгай зөвшөөрлийн зохицуулалт;

## ҮТЗЗГ

1. Шинэ эх үүсвэрийн үнэ тариф (уламжлалт эх үүсвэр)-ын зохицуулалт;
2. Дулаан түгээх, хангах компаниудын тарифын зохицуулалт;

## ЭХХГ

1. ЭХХ төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;
2. ЭХХ-ийн талаар үндэсний хөтөлбөр боловсруулах ажлыг зохион байгуулах;
3. Эрчим хүчний аудитор, эрчим хүчний хэмнэлтийн менежерийн эрх олгох;
4. Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох, хүчингүй болгох;
5. Эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээтэй холбогдон гарсан аливаа маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх;

## ХОНХ

1. Хэрэглэгчийн өргөдөл, гомдол шийдвэрлэсэн байдал;
2. АНЗЗ-ийн үйл ажиллагаанд;



**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА**